



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2028 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/510

Үсөнбулаг

┌ Комисс томилох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто замын тухай хуулийн 28.1, 28.2 дахь хэсэг, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


1. Аймгийн орон нутгийн авто замын санхүүжилтээр хийгдсэн Цээл сумын шинэ суурьшлын бүсэд хатуу хучилттай авто зам барих ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | | |
|-----------------------|---------------|--|
| Комиссын дарга: | Б.Бямбадорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор) |
| Гишүүдэд: | М.Мандаххүү | (Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга) |
| | Г.Мөнхөө | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто замын хяналтын улсын байцаагч) |
| | Д.Буянхишиг | (Цээл сумын Засаг дарга) |
| | Ж.Билэгсайхан | (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн) |
| | Б.Цэрэндаваа | (Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын Барилга угсралт техник хяналт хариуцсан мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | С.Дугарсүрэн | ("Сод энх констракшн" ХХК-ийн инженер) (гүйцэтгэгч) |

2. Авто замын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, автозамын байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаацдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:\Documents\ ZD A-4 doc

0201050828

